

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ




11 дүгээр зүйлийг
хэрэгжүүлэх
Удирдамж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL



ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

ТХСК-ийн 11 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“Тамхин бүтээгдэхүүний
хайрцаг, сав, баглаа,
боодол, шошгололтын
тухай”

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/packaging-and-labelling-of-tobacco-products>

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 11 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

ТАМХИН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХАЙРЦАГ, САВ, БАГЛАА, БООДОЛ, ШОШГОЛОЛТЫН ТУХАЙ

ЗОРИЛГО, ЗАРЧИМ, НЭР ТОМЪЁО

Зорилго

ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцийн бусад заалт, Конвенцийн Талуудын Бага Хурлын зорилготой нийцүүлэн Оролцогч талууд конвенцийн 11 дүгээр зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь туслах, тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошгололтын талаар хэрэгжүүлэх арга хэмжээний үр нөлөг нэмэгдүүлэхэд ашиглаж болох арга хэмжээг санал болгоход эдгээр удирдамжууд чиглэгдэнэ. 11 дүгээр зүйлд Оролцогч тал бүр конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 3 жилийн дотор тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны үр нөлөөтэй арга хэмжээ авах ёстойг заасан.

Зарчим

Конвенц болон түүний протоколуудын зорилтод хүрэх, тэдгээрийн заалтуудыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд Конвенцийн 4 дүгээр зүйлд Оролцогч талууд тамхины хэрэглээ, дам тамхидалтын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл, донтуулах чанар, амь насанд учруулах аюул заналын талаар хүн бүрт мэдээлэх зарчмыг баримтлах ёстой гэж заасан.

Дэлхий дахинд олон хүн тамхины хэрэглээ, дам тамхидалтын улмаас нас барах, өвдөх эрсдэлийг бүрэн ойлгохгүй байх, буруу ойлгох, эсхүл дутуу үнэлэх явдал түгээмэл байна. Тамхины хайрцаг, сав, баглаа, боодол дээр сайтар төлөвлөсөн эрүүл мэндийн анхааруулга тавих нь тамхины хэрэглээний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, тамхины хэрэглүүлэх бууруулах үр дүнтэй арга юм. Эрүүл мэндийн анхааруулга, тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол, шошгололтын бусад арга хэмжээ нь тамхины хяналтын цогц арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг юм.

Оролцогч талууд хайрцаг, сав, баглаа, боодол, шошгололтын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ бусад улсын туршлагад тулгуурлаж, хамгийн үр дүнтэй боломжит арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорино.

Конвенцийн 20, 22 дугаар зүйлд зааснаар олон улсын хамтын ажиллагаа нь Оролцогч талуудын конвенцийн 11 дүгээр зүйлийг бүрэн хэрэгжүүлэх, үр нөлөөг сайжруулах чадавхийг бэхжүүлэх үндсэн зарчим юм.

Нэр томъёо

Энэхүү удирдамжид доорх нэр томъёог дараах утгаар ашигласан болно. Үүнд:

- “хуулийн арга хэмжээ” гэж тухайн улсын хуульд нийцсэн үүрэг, шаардлага, хориглох зүйлийг тогтоосон эрх зүйн арга хэрэгслийг ойлгоно. Тухайлбал, эрх зүйн акт, хууль, журам, захиргааны тушаал г.м.
- “хавчуулга” гэж хэрэглэгчийн жижиглэнгээр худалдан авсан тамхины хайрцаг, сав доторх танилцуулга, санамж зэрэг мэдээллийг ойлгоно.
- “наалт” гэж хэрэглэгчийн жижиглэнгээр худалдаж авсан тамхины хайрцаг, савны гадна бэхэлсэн танилцуулга, санамж зэрэг мэдээллийг ойлгоно. Тухайлбал, гадна гялгар уутан дор хийсэн, эсхүл тамхины хайрцагны гадна наасан санамж.

ТАМХИНЫ ХАЙРЦАГ, САВ, БАГЛАА, БООДОЛ, ШОШГОЛОЛТОД ТАВИХ ҮР ДҮНТЭЙ ШААРДЛАГА БОЛОВСРУУЛАХ

Сайтар төлөвлөсөн эрүүл мэндийн анхааруулга нь эрүүл мэндийн эрсдэлийг мэдээлэх, тамхины хэрэглээг бууруулах үр дүнтэй арга хэмжээний бүрэлдэхүүн хэсэг юм. Эрүүл мэндийн анхааруулга нүдэнд өртөхүйц байх тусмаа илүү үр дүнтэй болохыг нотолгоо харуулж байна. Жижиг, дан үгэн эрүүл мэндийн анхааруулгатай харьцуулахад зураг буюу дүрс бүхий том анхааруулга нь эрүүл мэндийн эрсдэлийг илүү таниулж, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийг өдөөж, тамхи хэрэглэгчдийн тамхиа хаях сэдлийг нэмэгдүүлдэг байна. Түүнчлэн том зурагтай анхааруулгын үр нөлөөг илүү удаан хадгалагдаж, ялангуяа бичиг үсэг тайлагдаагүй хүн ам, хүүхэд, залууст тамхины эрүүл мэндийн хор хөнөөлийг таниулахад онцгой ач холбогдолтой. Эрүүл мэндийн анхааруулгыг тамхины хайрцаг, сав, баглаа, боодлын эргэн тойрны гадаргуу дээр байрлуулах, хар/цагаан бус өнгөтөөр хийх, нэгэн зэрэг олон төрлийн анхааруулгыг ашиглах, эрүүл мэндийн анхааруулгыг үе үе хянах зэрэг нь үр нөлөөг нэмэгдүүлдэг байна.

Анхааруулгын загвар

Байршил

Конвенцийн 11.1(b)(iii) дүгээр зүйлд Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгыг том хэмжээтэй, тод, харагдахуйц, уншигдахуйц байлгах талаар үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлэхийг заасан. Хайрцаг, сав, баглаа, боодол дээрх эрүүл мэндийн анхааруулгын байршил, дизайн нь нүдэнд хамгийн их өртөхүйц байх ёстой. Эрүүл мэндийн анхааруулга нь хайрцагны нүүр болон ар талын доод хэсэгт байснаас дээд хэсэгт байх нь нүдэнд илүү өртдөг болохыг судалгаагаар нэгэнт тогтоосон байна. Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгыг байршуулахад дараах шаардлага тавина:

- эрүүл мэндийн анхааруулгыг нэгж хайрцаг, сав, баглаа, боодлын зөвхөн нэг талд бус, нүүр болон ар талын аль алинд нь (эсхүл хоёроос олон талтай бол бүх нүүрэн хэсэгт) харагдахуйц байдлаар байрлуулах;
- тамхины хайрцагны эргэн тойрны гадаргуу, ялангуяа гадаргуун доод ба дээд талд нь байрлуулах;
- хайрцгийг онгойлгоход эрүүл мэндийн анхааруулгын бичвэр буюу зураг гэмтэхгүй буюу халхлагдахгүй байх.

Оролцогч талууд 8 дугаар хэсэгт дурдсан эрүүл мэндийн анхааруулгаас гадна нэмэлт анхааруулгыг хайрцаг, сав, баглаа, боодлын бүх талд байршуулж,

анхааруулга бүхий хавчуулга, наалт хийх шаардлага тавихыг эрмэлзэх ёстой.

Оролцогч талууд хайрцаг, сав, баглаа, боодол дээр тавих бусад тэмдэглэгээ буюу худалдааны хавчуулга, наалтыг эрүүл мэндийн анхааруулгад саад болгохгүй байлгах арга хэмжээ авна. Тухайлбал, Оролцогч талууд татварын тэмдэг, конвенцийн 15 дугаар зүйлд шаардсан тэмдэглэгээ зэрэг бусад тэмдгийн хэмжээ, байршлыг тогтоохдоо тэдгээр нь эрүүл мэндийн анхааруулгын аль ч хэсэгт саад болохгүй байхаар тооцоолж тогтооно.

Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын байршилтай холбоотой бүтээлч арга хэмжээ авах, тухайлбал, янжуур тамхины шүүлтүүрийн хэсэг, янжуур тамхины соруул, цаас зэрэг бусад хэрэгсэл дээр эрүүл мэндийн анхааруулгыг хэвлэхийг шаардах талаар арга хэмжээ авах ёстой.

Хэмжээ

Конвенцийн 11.1(b)(iv) дүгээр зүйлд тамхин бүтээгдэхүүн дээрх эрүүл мэндийн анхааруулга нь тамхины хайрцагны эргэн тойрны гадаргуун 50 хувиас их, 30 хувиас багагүй талбаг эзлэх ёстойг тогтоосон. Хэмжээнээс хамаарч эрүүл мэндийн анхааруулгын үр нөлөө нэмэгддэг болохыг нотолгоо харуулж байгаа тул Оролцогч талууд тамхины хайрцагны эргэн тойрны гадаргуун 50-иас илүү хувийг эзэлсэн эрүүл мэндийн анхааруулга ашиглахыг зорино. Эрүүл мэндийн анхааруулгын бичвэр нь том, тод, хялбар уншигдах үсгийн фонтоор бичигдэх ёстой бөгөөд ерөнхий харагдах болон уншигдах байдлыг сайжруулсан тухайлсан хэв маяг, өнгөтэй байна.

Хэрэв анхааруулгыг хүрээлэх шаардлагатай бол Оролцогч талууд хүрээний зайг эрүүл мэндийн анхааруулгын талбайн хэмжээнд оруулахгүй байх ёстой. Өөрөөр хэлбэл хүрээнд зориулагдсан зайг эрүүл мэндийн анхааруулгын эзлэх нийт талбайд оруулалгүйгээр, түүн дээр нэмж тооцох ёстой.

Зураг, дүрслэл ашиглах

Конвенцийн 11.1(b)(v) дүгээр зүйлд тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол болон шошгон дээрх эрүүл мэндийн анхааруулга нь зураг эсхүл дүрс хэлбэрээр байж болох талаар заасан. Зураг болон бичвэрийн хоёулангаас нь бүрдсэн эрүүл мэндийн анхааруулга нь дан ганц бичвэр бүхий анхааруулгаас хавьгүй илүү үр дүнтэй болохыг баримт харуулж байна. Түүнчлэн энэ нь бичиг үсэг тайлагдаагүй хүмүүст эрүүл мэндийн анхааруулгыг хүргэхэд үлэмж ач холбогдолтой юм. Хайрцаг, сав, баглаа, боодол, шошгон дээрх зураг, дүрс нь зан заншилд тохирсон, өнгөт байх шаардлагыг Оролцогч талууд тавина. Тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодлын нүүр болон ар талын аль алинд нь (эсхүл хоёроос олон талтай бол бүх нүүрэн хэсэгт) зураг, дүрслэл бүхий эрүүл мэндийн анхааруулгыг хэрэглэх талаар Оролцогч талууд анхаарах ёстой.

Зураг, дүрслэл бүхий эрүүл мэндийн анхааруулгыг дан ганц бичвэр бүхий анхааруулгатай харьцуулахад:

- нүдэнд илүү амар өртдөг;
- тамхи хэрэглэгчид илүү үр нөлөөтэй хэмээн үнэлдэг;
- удаан хугацаанд ач холбогдол нь хэвээр хадгалагддаг;
- тамхины хэрэглээний эрүүл мэндийн эрсдэлийг илүү сайн мэдээлдэг;
- гарах бодлыг илүүтэй төрүүлдэг;
- тамхинаас гарах сэдлийг нэмэгдүүлдэг;

- тамхинаас гарах оролдлогыг нэмэгдүүлдэг болохыг баримт харуулж байна.

Зураг, дүрс бүхий эрүүл мэндийн анхааруулга нь тамхины үзэмжид сөргөөр нөлөөлж, тамхины хайрцаг, сав, баглаа, боодлын ерөнхий харагдах байдлыг бууруулдаг.

Тамхины хайрцаг, сав, баглаа, боодолд хэрэглэх зураг, дүрслэлийн зохиогчийн эрхийг Оролцогч талууд эзэмших нь зүйтэй. Энэ нь ухуулга, сурталчилгааны кампанит ажил, интернэт зэрэг тамхины хяналтын бусад үйл ажиллагаанд эдгээр зураг, дүрслэлийг ашиглах боломжийг нэмэгдүүлдэг. Мөн Оролцогч талуудад зураг, дүрслэл ашиглах зөвшөөрлийг бусдад олгох боломж бий болгоно.

Өнгө

Дан хар, цагаанаас гадна бусад өнгийг эрүүл мэндийн анхааруулгын зураг, дүрслэлд ашиглах нь түүний нүдэнд өртөх байдлыг сайжруулдаг. Тиймээс Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын зураг, дүрслэлийг дан хар, цагаанаар бус, дөрвөн өнгөт хэвлэлээр хэвлэхийг шаардах ёстой. Талууд эрүүл мэндийн анхааруулгын харагдах байдлыг сайжруулахын тулд үсэг тод ялгагдах өнгийн суурин дээр анхааруулгын бичвэрийг хийхийг шаардана.

Анхааруулгыг үе үе солих

Конвенцийн 11.1(b)(ii) дүгээр зүйлд эрүүл мэндийн анхааруулгыг үе үе сольж байх талаар заасан. Ингэхдээ олон төрлийн эрүүл мэндийн анхааруулгыг нэгэн зэрэг ашиглах, эсхүл нэг анхааруулгыг тодорхой хугацааны турш ашиглаж, өөрөөр солих аргыг ашиглаж болно. Оролцогч талууд дээрх хоёр аргын аль алийг нь хэрэглэх нь зүйтэй.

Эрүүл мэндийн шинэ анхааруулгын шинэлэг нөлөөлөл чухал бөгөөд эрүүл мэндийн анхааруулгыг давтан ашиглах нь түүний үр нөлөөг сайжруулж, эрүүл мэндийн анхааруулгыг өөрчлөх нь үр дүнг нь нэмэгдүүлдэг болохыг судалгаа харуулж байна. Эрүүл мэндийн анхааруулгыг үе үе солих, загварыг өөрчлөх нь анхааруулгын ач холбогдол, үр нөлөөг сайжруулахад чухал юм.

Оролцогч талууд нэгэн зэрэг хэдэн төрлийн эрүүл мэндийн анхааруулга гаргаж болох тоог тогтоож өгнө. Түүнчлэн Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгыг тогтоосон цувралаар хэвлэхийг шаардах ба ингэснээр анхааруулгын төрөл тус бүр жижиглэнгээр худалдаалж буй хайрцаг, сав, баглаа бүрт, мөн зөвхөн дан ганц брэндэд бус тухайн брэндийн бүх төрлийн бүтээгдэхүүнд ижил тоо хэмжээгээр гарах юм.

Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын хоёр ба түүнээс дээш багцыг гаргахад анхаарах ёстой бөгөөд тодорхой хугацааны дараа, тухайлбал 12-36 сар тутамд нэг багцыг нөгөөгөөр солих шаардлага тавина. Нэг багцыг нөгөөгөөр солих шилжилтийн үед Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын шинэ, хуучин багцыг нэгэн зэрэг хэрэглэж болох шилжилтийн үе байхаар зохицуулга хийж өгөх ёстой.

Анхааруулгын агуулга

Олон төрлийн эрүүл мэндийн анхааруулгыг хэрэглэх нь үр нөлөөг нь нэмэгдүүлдэг. Эрүүл мэндийн анхааруулга нь тамхитай холбоотой янз бүрийн асуудал, тухайлбал эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, дам тамхидалтын нөлөө зэрэгт чиглэсэн байна. Тухайлбал:

- тамхинаас хэрхэн гарах талаар зөвлөгөө;
- тамхины донтуулах чанар;
- эдийн засаг, нийгмийн сөрөг үр нөлөө (тухайлбал, тамхин бүтээгдэхүүн худалдан авах жилийн нийт зардал г.м.);
- тамхины хэрэглээний бусдад үзүүлэх нөлөө (тухайлбал, хэн нэгний аав тамхинаас болж залуудаа өвчилсөн, эсхүл дам тамхидалтаас болж хэн нэгний хайртай хүн нас барсан тухай г.м.).

Түүнчлэн Оролцогч талууд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, тамхины үйлдвэрлэлийн сөрөг ажиллагаа зэрэг бусад агуулгыг анхааруулгад тусгах талаар анхаарна.

Эрүүл мэндийн анхааруулгыг үр дүнтэй байдлаар илэрхийлэх нь чухал; өөрөөр хэлбэл, өнгө аяс нь итгэл, найдвар төрөхүйц, мэдээлэл сайтай байх ёстой, харин буруутгасан байж болохгүй. Түүнчлэн эрүүл мэндийн анхааруулга нь энгийн, ойлгомжтой хэллэгтэй, зан заншилд тохирсон байх ёстой. Эрүүл мэндийн анхааруулга нь янз бүрийн хэлбэртэй байж болно, тухайлбал хэн нэгний өгүүлсэн бодит түүх, эерэг, дэмжсэн мэдээлэл г.м.

Эрүүл мэндийн анхааруулга нь тамхины хэрэглээний талаар таагүй сэтгэгдэл төрүүлж, итгэх төрүүлэхүйц, хувь хүнд өөрт нь хамаатай байж чадвал илүү үр дүнтэй болохыг баримт, нотолгоо харуулж байна. Айдас төрүүлэх зэрэг сөрөг сэтгэл хөдлөлийг өдөөхүйц эрүүл мэндийн анхааруулгыг тамхичдын тамхинаас гарах сэдлийг бататгах мэдээлэлтэй хамт хэрэглэвэл үр дүнтэй байж болдог.

Тамхинаас гарах тухай зөвлөгөө бүхий анхааруулга дээр тамхинаас гарахад нь туслах үйлчилгээний тухай мэдээ, тухайлбал, вэб хуудасны хаяг, зөвлөгөө өгөх төлбөргүй утасны дугаар зэргийг тавих нь тамхичдад зан үйлээ өөрчлөхөд нь туслахад чухал байж болно. Үүний дүнд тамхинаас гарахад туслах үйлчилгээний хэрэгцээ өсөн нэмэгдэж болзошгүй тул Оролцогч талууд бэлэн байдлаа хангах ёстой.

Хэл

Конвенцийн 11.3 дугаар зүйлд 11.1(b) болон 11.2 дугаар зүйлд заасан анхааруулга болон бусад бичвэр бүхий мэдээллийг нэгж хайрцаг, сав, баглаа, боодол, тамхин бүтээгдэхүүний гадна талын хайрцаг, сав, баглаа, боодол тус бүр дээр Оролцогч талын албан ёсны хэлээр бичигдсэн байхаар заажээ.

Тухайн нутаг дэвсгэрт нэгээс дээш албан ёсны хэл байгаа тохиолдолд эрүүл мэндийн анхааруулгыг хэл тус бүрээр хайрцагны гадаргуу болгон дээр, эсхүл гадаргуу тус бүр дээр нэг хэлээр бичиж болно. Түүнчлэн тодорхой орон нутагт борлуулагдах тамхин бүтээгдэхүүн дээр тухайн нутагт тохирсон хэлээр эрүүл мэндийн анхааруулгыг бичиж болох юм.

Эх сурвалжийн тухай тэмдэглэгээ

Зарим тохиолдолд тамхин бүтээгдэхүүн дээрх эрүүл мэндийн анхааруулгын эх сурвалжийг тэмдэглэдэг. Гэхдээ ийнхүү эх сурвалжийг заах шаардлагатай эсэх талаар хүмүүсийн үзэл бодол харилцан адилгүй байдаг. Зарим улсад эх сурвалжийг дурдах нь анхааруулгад итгэх итгэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг бол нөгөө хэсэг нь үүнийг санамжийн нөлөөг бууруулж болзошгүй хэмээн үзэж хэрэглэдэггүй байна. Эх сурвалжийн тухай тэмдэглэгээ шаардлагатай гэж үзсэн нөхцөлд тэмдэглэгээг эрүүл мэндийн санамжаас жижиг хэмжээтэй үсгийн

фонтоор, санамжийн төгсгөлд бичиж байрлуулдаг. Эх сурвалжийн тухай тэмдэглэгээг хэрэглэснээр агуулгад итгэх итгэл нэмэгдэх үү, эсвэл санамжийн нөлөө буурах уу гэдгийг тухайн Оролцогч талын зорилтот хүн амын итгэл үнэмшил болон хандлагаас хамаарч тодорхойлох асуудал юм.

Эх сурвалжийн тэмдэглэгээ хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Эрүүл мэндийн яам зэрэг итгэл төрүүлэхүйц мэргэжлийн эх сурвалжийг заах нь чухал юм. Энэхүү тэмдэглэгээ нь анхааруулгын нүдэнд өртөх байдал, үр нөлөөг бууруулахааргүй жижиг хэрнээ гаргацтай байна.

Орц найрлага болон ялгаруулах бодисын талаарх мэдээлэл

Конвенцийн 11.2 дугаар зүйлд нэгж хайрцаг, сав, баглаа, боодол, тамхин бүтээгдэхүүний гадна талын хайрцаг, сав, баглаа, боодол нь Конвенцийн 11.1(b)-д заасан эрүүл мэндийн анхааруулгаас гадна үндэсний эрх бүхий байгууллагаас тодорхойлсны дагуу тамхин бүтээгдэхүүний орц найрлага болон ялгаруулах бодисын талаарх мэдээллийг агуулсан байна.

Энэхүү үүргийн биелүүлэхдээ Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүнээс ялгарах бодисын талаарх мэдээллийг нэгж хайрцаг, сав, баглаа, боодол болгон дээр тавихыг шаардана. Тухайлбал, “энэхүү янжуураас гарах утаанд хорт хавдар үүсгэгч бодис болох бензол агуулагддаг”, “тамхи татсанаар та хорт хавдар үүсгэгч 60 гаруй химийн бодист өртөнө” гэсэн мэдээллийг тавьж болно. Энэхүү мэдээллийг бүтээгдэхүүний эрүүл мэндийн анхааруулга бичээгүй хэсэг (савлагааны хажуу тал г.м.)-т байрлуулах шаардлагыг Оролцогч талууд тавина.

Оролцогч талууд тамхины бохь, никотин болон нүүрстөрөгчийн дан ислийн хэмжээг заах буюу “энэ тамхи нитрозамины агууламж багатай” гэх мэт аль нэг брэндийг нөгөөгөөс хор багатай гэсжн санаа агуулсан мэдээллийг тамхин бүтээгдэхүүний савлагаа, шошгон дээр тавихыг шаардаж болохгүй.

Дээрх 3 хэсгийг “Хайрцаг, сав, баглаа, боодол шошгон дээр худал, ташаа мэдээлэл тавихаас сэргийлэх” хэсгийн хамтаар уншиж хэрэгжүүлнэ.

ТАМХИНЫ ХАЙРЦАГ, САВ, БАГЛАА, БООДОЛ, ШОШГОЛОЛТОД ТАВИХ ШААРДЛАГА БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Бүтээгдэхүүний төрөлтэй холбоотой асуудал

Конвенцийн 11.1(b) дүгээр зүйлд конвенцид нэгдэн орсон бүх Оролцогч талыг нэгж хайрцаг, сав, баглаа, боодол, тамхин бүтээгдэхүүний гадна талын хайрцаг, сав, баглаа, боодол дээр эрүүл мэндийн анхааруулга тавих үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардсан байдаг. Бага хэмжээний үйлдвэрлэл бүхий компани, брэндийн бүтээгдэхүүн, тамхин бүтээгдэхүүний тодорхой төрлийг энэхүү шаардлагаас чөлөөлж болохгүй. Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүний төрөл тус бүр (ж.нь, янжуур, навчин тамхи, утаагүй тамхи, дүнсэн тамхи, соруулт тамхи)-ийн онцлогт тохирсон эрүүл мэндийн анхааруулга ашиглах шаардлагыг тавина.

Савлалтын төрөл

Оролцогч талууд өөрийн газар нутагт ямар савлагаатай тамхин бүтээгдэхүүн хэрэглэгддэг талаар өргөн хүрээний ойлголттой байж, эрүүл мэндийн анхааруулгыг савлагаа (лааз, хайрцаг, уут, дардаг тагтай сав, гулгаж онгойдог хайрцаг, хатуу хайрцаг, тунгалаг боодол, тунгалаг хайрцаг буюу нэгж бүтээгдэхүүн бүхий баглаа) тус бүрт хэрхэн хэрэглэхийг тодорхойлон заах хэрэгтэй.

Хүн амын зорилтот бүлэгт чиглэх

Залуучууд зэрэг хүн амын зорилтот бүлэгт зориулсан эрүүл мэндийн анхааруулгыг боловсруулж, тодорхой давтамжтайгаар, үе үе сольж гаргана.

Зах зээлд гаргахын өмнөх туршилт

Нөөцийн болон цаг хугацааны боломжоос хамааран Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын зорилтот хүн амд үзүүлэх үр нөлөөг үнэлэх зорилгоор бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахын өмнө туршина. Ийн туршилт хийх нь анхааруулга тамхи татах дур хүслийг санамсаргүй нэмэгдүүлэх зэрэг урьдчилан тооцоогүй үр нөлөө үзүүлэх эсэх, зан заншилд тохиромжтой эсэхийг үнэлэхэд тусалдаг. Энэхүү үйл ажиллагаанд тамхи үйлдвэрлэгчтэй холбоогүй иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулах хэрэгтэй. Ер нь, зах зээлд гаргахын өмнө туршилт хийх нь хожим эрх зүйн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс бага зардалтай байдаг.

Зах зээлд гаргахын өмнөх туршилт нь удаан хугацааны, нарийн түвэгтэй, зардал ихтэй байх шаардлагагүй гэдгийг Оролцогч талууд анхаарах хэрэгтэй. Зорилтот хүн амын бүлгээс ярилцлага авч, үнэ цэнэтэй мэдээлэл олох боломжтой. Мөн интернэтээр мэдээлэл цуглуулах нь хурдан бөгөөд хямд төсөр сонголт болно. Хэрэгжилтийг цаг алдалгүй гүйцэлдүүлэх үүднээс зах зээлд гаргахын өмнөх туршилтыг эрх зүйн арга хэмжээ төлөвлөх ажилтай нэгэн зэрэг хийж болно.

Олон нийтийн мэдээлэл, оролцоо

Оролцогч талууд эрүүл мэндийн шинэ анхааруулга нэвтрүүлэх саналыг олон нийтэд мэдээлэх хэрэгтэй. Олон нийтийн дэмжлэгийг авах нь Оролцогч талуудад эрүүл мэндийн шинэ анхааруулгыг нэвтрүүлэхэд тус болно. Гэхдээ олон нийтэд мэдээлэх, олон нийтийн оролцоог хангахын тулд конвенцийн хэрэгжилтийг удаашруулахаас сэргийлэх нь зүйтэй.

Харилцаа холбооны үйл ажиллагааг дэмжих

Эрүүл мэндийн шинэ анхааруулгыг нэвтрүүлэхдээ түүнийг олон нийтэд таниулах өргөн хүрээний, тогтвортой кампанит ажилтай хослуулбал илүү үр дүнтэй байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүүл мэндийн шинэ анхааруулгын талаар мэдээлэх нь энэ талаар олон нийтэд таниулахад тустай тул хэвлэл мэдээллийн хэрэгслээр цаг алдалгүй дамжуулах нь чухал.

ТАМХИНЫ ХАЙРЦАГ, САВ, БАГЛАА, БООДОЛ, ШОШГОЛОЛТОД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

Хайрцаг, сав, баглаа, боодол, шошгон худлаа, ташаа мэдээлэл тавихаас сэргийлэх

Конвенцийн 11.1(a) дугаар заалтад Оролцогч талууд өөрийн хууль тогтоомжид нийцүүлэн тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошго зэрэг нь аль нэг тамхин бүтээгдэхүүн нөгөөгөөс хор багатай гэсэн ташаа ойлголтыг шууд буюу шууд бусаар төрүүлэх нэр томъёо, зураг, худалдааны тэмдэг, уран дүрслэлийн буюу бусад тэмдэглэгээ ашиглах замаар тамхин бүтээгдэхүүнийг сурталчлахгүй байх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлнэ хэмээн заасан. Үүнд буруу сэтгэгдэл төрүүлж болохуйц “бохь багатай”, “зөөлөн”, “хэт зөөлөн”, “зөөлөвтөр” гэх мэт болон бусад үг хэллэг мөн хамаарна. Конвенцийн Article 11.1(a) заалтын дагуу үүргээ хэрэгжүүлэхдээ Оролцогч талууд зөвхөн дурьдсан нэр томъёог хэрэглэхийг хориод зогсохгүй, хэрэглэгчдийг төөрөгдүүлж болох “онцгой, хэт” гэх мэтийн болон түүнтэй төстэй нэр томъёог ямар ч хэлээр хэрэглэхийг хориглох нь зүйтэй.

Оролцогч талууд тамхинаас ялгарах бодис (тамхины бохь, никотин, нүүрстөрөгчийн дан исэл г.м.)-ийн арга хэмжээ заасан тоог брэндийн нэр буюу худалдааны тэмдгийн нэг хэсэг болгох эсвэл өөрөөр тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошгон дээр заахыг хориглох шаардлагатай. Машин дээр туршихад тамхинаас ялгарах бохь, никотин, нүүрсхүчлийн дан ислийн хэмжээ нь тамхийг хүн татах үеийн хэмжээтэй адил байдаггүй. Түүнээс гадна машины туршилтаар бодисын ялгаралт багатай гарсан тамхи бусад утаа ялгаралт ихтэй тамхитай харьцуулахад хүний эрүүл мэндэд хор багатай гэсэн шинжлэх ухааны болон тархвар судлалын баттай нотолгоо байдаггүй. Тамхины бохь, никотины хэмжээг бичиж зах зээлд гаргах нь тухайн тамхийг хор багатай гэж буруу ойлгоход хүргэж болзошгүй юм.

Оролцогч талууд тамхийг ямар ч үед хэрэглэхэд аюулгүй гэсэн ташаа ойлголтод хүргэж болохуйц байдлаар тамхины хайрцаг, сав, баглаа, боодол дээр хугацаан дуусах огноо заахаас сэргийлэх хэрэгтэй.

Ердийн савлагаа

Оролцогч талууд брэндийн нэрийг стандарт өнгө, үсгийн фонтоор гаргах (ердийн савлагаа)-аас өөр байдлаар лого, өнгө, брэндийн дүрс, бусад сурталчилгааны мэдээллийг тамхины савлагаан дээр хэрэглэхийг хориглох арга хэмжээ авах нь зүйтэй. Ингэснээр эрүүл мэндийн анхааруулгын ялгарч харагдах байдал, үр нэмэгдэж, савлагаа нь эрүүл мэндийн санамжаас анхаарлыг хөндийрүүлэхээс, мөн зарим нэг бүтээгдэхүүн нь бусдаас хор багатай гэсэн санаа төрүүлэхээс сэргийлдэг.

ЭРХ ЗҮЙН АРГА ХЭМЖЭЭ

Төлөвлөлт

Тамхи, тамхин бүтээгдэхүүний савлагаа, шошгололтын талаар эрх зүйн арга хэмжээг төлөвлөхдөө Оролцогч талууд хэрэгжилтийг хариуцах эзэн, хэрэгжилтийг хангах боломжит арга зам, төрийн оролцооны түвшин зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

Хэрэгжилт

Оролцогч талууд тамхи, тамхин бүтээгдэхүүний савлагаа, шошгололтын талаар эрх зүйн арга хэмжээний хэрэгжилтийг хянах эрх бүхий этгээдийг томилох хэрэгтэй. Мөн тамхины хяналтын асуудлыг хариуцсан холбогдох этгээдэд эрх зүйн арга хэмжээний хэрэгжилтийг хариуцуулах боломжийг судалж үзэх нь зүйтэй. Хэрэв төрийн өөр байгууллагад үүнийг хариуцуулбал эрүүл мэндийн холбогдох эрх бүхий байгууллагын санаа бодлыг харгалзан үзэх шаардлагатай.

Цар хүрээ

Конвенцийн 11 дүгээр зүйлийн тамхи, тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны талаар заалтууд нь Оролцогч талын харъяаллын газар нутаг дээр борлуулагдаж буй бүх төрлийн тамхин бүтээгдэхүүнд ижил тэгш хамаарах бөгөөд дотоодод үйлдвэрлэсэн, импортлосон, эсвэл тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд татваргүй борлуулах зориулалттай бүтээгдэхүүний хооронд ямар нэг ялгаа зааг гаргахгүй байх нөхцлийг Оролцогч талууд хангана. Экспортын бүтээгдэхүүнд дээрх нөхцлүүд хэрхэн хамаарахыг Оролцогч талууд тогтооно.

Зардал

Оролцогч талууд тамхи, тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол дээр эрүүл мэндийн анхааруулга, бүтээгдэхүүний орц найрлага, ялгаруулах бодисын талаарх мэдээллийг байршуулах зардлыг тамхины үйлдвэрээр төлүүлнэ.

Үүрэг хариуцлага

Конвенцийн 19 дүгээр зүйлд нийцүүлэн Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүн дээр эрүүл мэндийн анхааруулга байршуулах, тамхины талаар олон нийтэд мэдээлэл хүргэх нь тамхи үйлдвэрлэгчийг тамхины хэрэглээ болон дам тамхины нөлөөнөөс эрүүл мэндэд учирч болох хор аюулын талаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх зэрэг үүрэг хариуцлагаас чөлөөлөх буюу хөнгөвчлөхгүй болох талаар эрх зүйн орчин бүрдүүлнэ.

Тусгайлсан заалт

Тамхи үйлдвэрлэгчид болон импортлогчид эрүүл мэндийн анхааруулгын талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийг гажуудуулах боломжийг хязгаарлах, түүнчлэн тамхин бүтээгдэхүүний төрлүүдэд анхааруулгыг ижил бусаар хэрэглэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Оролцогч талууд эрх зүйн тусгайлсан, тодорхой, дэлгэрэнгүй заалт оруулна. Ийм арга хэмжээг төлөвлөхдөө Оролцогч талууд дор дурьдсан (гэвч үүгээр хязгаарлагдахгүй) жагсаалтыг харгалзана. Үүнд:

- хайрцаг, сав, баглаа, боодол болон бүтээгдэхүүн (37 дугаар хэсгээс хар);
- бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол дээрх заавал шаардсан эрүүл мэндийн анхааруулга болон орц найрлага, ялгаруулах бодисын талаарх мэдээлэлд хэрэглэх хэл, хэрэв нэгээс олон хэлээр бичих бол анхааруулгыг хаана хэрхэн байршуулах тухай;
- нэг зэрэг гарах эрүүл мэндийн санамжийн тоо, солигдох хугацаа,

шилжилтийн үеийн үргэлжлэх хугацаа, шинэ санамж гаргах эцсийн хугацаа;

- зөвхөн брэнд тус бүрээр бус дэд брэнд тус бүрийн хайрцаг, сав, баглаа, боодол, төрөл нэг бүрээр жижиглэнгийн савлагаан дээр эрүүл мэндийн анхааруулгыг жигд гаргах хуваарилалтын арга;
- тамхины хайрцаг, сав, баглаа, боодол дээр завсар болон дотор байршуулах эрүүл мэндийн анхааруулгын бичвэр, зураг, дүрс зэргийг хайрцаг, сав, баглаа, боодол дээр хэрхэн харуулах (байрлал, хэмжээ, өнгө, үсгийн хэмжээ, хэвлэлийн чанар гэх мэт);
- хэрэв тохиромжтой бол тамхин бүтээгдэхүүний төрөл тус бүрд тохирсон өөр өөр эрүүл мэндийн анхааруулга;
- хэрэв тохиромжтой бол эх сурвалжийн тухай тэмдэглэгээний байрлал, бичвэр, үсгийн хэмжээ (эрүүл мэндийн анхааруулгын тухай заалттай адил дэлгэрэнгүй);
- конвенцийн 11.1(а) дүгээр заалтад нийцүүлэн худал, ташаа, эсвэл ташаа ойлголт төрүүлж болох арга хэлбэрийн сурталчилгааг хориглох.

Эх сурвалжийн баримт бичиг

Оролцогч талууд эрүүл мэндийн бүх анхааруулга, бусад мэдээлэл тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа боодол дээр хэрхэн харагдах ёстойг чанарын өндөр түвшинд харуулсан дүрсний эх сурвалжийн баримт бичгийг гаргаж өгнө. Эх сурвалжийн баримт бичиг нь эрх зүйн баримт бичигт хэрэглэсэн үг хэллэг тодорхой бус тохиолдолд онцгой ач холбогдолтой юм.

Наалддаг шошго, таглаа

Наалддаг шошго, наалддаг тууз, сав, таглаа, боодол болон тамхи үйлдвэрлэгчийн сурталчилгааны наалт, хавчуулга зэрэг нь эрүүл мэндийн санамжийг арилгахгүй, халхлахгүй, далдлахгүй байх шаардлагыг Оролцогч талууд хангана. Тухайлбал, наалддаг шошгыг зөвхөн салж унахааргүй, янжуур тамхинаас өөр бүтээгдэхүүн бүхий модон буюу метал хайрцаг, саван дээр хэрэглэсэн тохиолдолд зөвшөөрнө.

Дагаж мөрдөх хууль ёсны үүрэг

Тамхи үйлдвэрлэгчид, импортлогчид, тамхи борлуулдаг бөөний болон жижиглэнгийн худалдаачид нь тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол, шошгонд тавих шаардлагыг биелүүлэх үүргийг хуулийн өмнө хүлээнэ гэдгийг Оролцогч талууд тодорхой зааж өгнө.

Торгууль, шийтгэл

Хууль зөрчих явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд Оролцогч талууд зөрчлийн хүнд, хөнгөн, давтан үйлдэл эсэхийг харгалзан тэдгээрт нийцсэн торгууль, шийтгэлийг тодорхой зааж өгөх шаардлагатай.

Оролцогч талууд өөрийн соёл ахуй, эрх зүйн тогтолцоотой нийцсэн бусад шийтгэлийг ч бий болгож болох бөгөөд үүнд бизнес эрхлэх, бүтээгдэхүүн импортлох тусгай зөвшөөрлийг цуцлах, түдгэлзүүлэх, хязгаарлах зэрэг арга хэмжээ багтаж болно.

Хууль сахиулах эрх мэдэл

Оролцогч талууд хууль зөрчигчдөөс шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг буцаах, ийнхүү буцааснаас үүдэн гарсан бүхий л зардлыг хариуцахыг шаардах, түүнчлэн шаардлага хангаагүй бараа бүтээгдэхүүнийг хураан авах, устгах зэрэг холбогдох арга хэмжээг авах эрх мэдлийг хууль сахиулах байгууллагуудад олгоно. Мөн Оролцогч талууд зөрчил гаргасан этгээдийн нэрийг зөрчлийн талаарх тодорхой мэдээллийн хамтаар нийтэд зарлана.

Хэрэгжүүлэх эцсийн хугацаа

Оролцогч талууд эрүүл мэндийн анхааруулгын талаарх эрх зүйн зохицуулалтын биелэлтийг хангах үүднээс үйлдвэрлэгчид, импортлогчид, бөөний болон жижиглэнгийн худалдаачид шинэ шаардлагад нийцсэн тамхин бүтээгдэхүүний нийлүүлэлт хийж эхлэх эцсийн хугацааг заана. Заасан энэхүү хугацаа нь үйлдвэрлэгчид болон импортлогчдод шинэ хайрцаг, сав, баглаа, боодлыг хэвлэх ажлыг зохион байгуулахад хүрэлцэхүйц хугацаа байна. Ихэнх тохиолдолд эрх зүйн арга хэмжээг баттай мөрдсөнөөс хойш 12 хүртэл сарын хугацааг үүнд хангалттай гэж үздэг.

Хяналт

Тамхин бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны талаар эрх зүйн арга хэмжээг төлөвлөх нь нэг удаа хийгээд өнгөрөх ажил биш гэдгийг Оролцогч талууд ойлговол зохино. Эрх зүйн арга хэмжээг тогтмол хугацаанд эргэн харж, хянан, шинэ нотолгоо бий болгох болон эрүүл мэндийн зарим анхааруулга үеэ өнгөрөөж, хуучирвал шинэчилж байх шаардлагатай. Анхааруулгыг тогтмол хугацаанд эргэн харж хянах буюу шинэчлэхдээ Оролцогч талууд хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний туршлага, бусад улсын туршлага зэргийг харгалзан үзэх нь зүйтэй. Ийн хяналт тавих болон шинэчлэн засах нь дутагдал, аливаа цоорхойг тодорхойлж, хэрэглэж буй хэл, хэллэгийг тодруулах хэрэгцээ шаардлагыг тогтооход ач холбогдолтой юм.

ХЭРЭГЖИЛТ

Дэд бүтэц, төсөв

Оролцогч талууд хэрэгжилтийг хангахад шаардлагатай дэд бүтцийг бий болгоно. Мөн шаардлагатай төсвийг бүрдүүлнэ.

Стратеги

Хэрэгжилтийг хангах үүднээс арга хэмжээ хүчин төгөлдөр болохоос өмнө Оролцогч талууд холбогдох субъектуудад хуулийн дагуу тавигдаж буй шаардлагуудыг таниулна. Тамхи үйлдвэрлэгчид, импортлогчид, бөөний болон жижиглэнгийн худалдаачид зэрэг субъектуудад харилцан адилгүй стратеги баримтлах шаардлагатай байж болзошгүй.

Байцаагчид буюу хууль сахиулагчдын хүчээр тамхин бүтээгдэхүүний үйлдвэрийн болон импортын бааз, борлуулалтын цэг зэрэгт газар дээр нь тогтмол шалгалт хийж, бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол, шошго

хуулийн шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянана. Шаардлагатай үед бизнесийн байранд үзлэг шалгалт хийхээр өргөжүүлж болох хяналтын тогтолцоо байгаа бол заавал шинэ хяналтын тогтолцоо бий болгох шаардлагагүй. Сонирхогч талуудад борлуулалтын цэгүүдэд тамхин бүтээгдэхүүний үзлэг шалгалт хийнэ гэдгийг мэдэгдэж болно.

Зөрчлийн үед авах хариу арга хэмжээ

Хууль сахиулах эрх бүхий байгууллага нь зөрчлийн үед цаг алдалгүй, шийдвэртэй арга хэмжээ авах бэлтгэлийг Оролцогч талууд хангана. Зөрчил илэрсэн эрт үед нь шийдвэртэй, цагаа олсон арга хэмжээ хэрэгжүүлснээр хууль, журмыг дагаж мөрдөхөөс өөр аргагүй гэдгийг тодорхой болгож, цаашдын хэрэгжилтийг хөнгөвчилдөг. Оролцогч талууд гарсан зөрчлийн мөрөөр шалгалт хийж, арга хэмжээ авдаг талаар олон нийтэд сануулга өгөх зорилгоор хууль дүрмийг сахиулах арга хэмжээний үр дүнг нийтэд зарлаж байх хэрэгтэй.

Өргөдөл, гомдол

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Оролцогч талууд хууль зөрчсөн үйлдлийн талаар мэдээлж байхыг олон нийтэд уриална. Хууль зөрчсөн тохиолдлын талаар мэдээлэхийн тулд холбоо барих цэгийг байгуулах нь зүйтэй. Оролцогч талууд өргөдөл, гомдлын мөрөө цаг алдалгүй шалгалт хийж, шийдвэрлэвэл зохино.

ТАМХИНЫ ХАЙРЦАГ, САВ, БАГЛАА, БООДОЛ, ШОШГОЛОЛТЫН ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЯНАЖ, ҮНЭЛЭХ ТУХАЙ

Оролцогч талууд тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны талаарх арга хэмжээг хянан, үр нөлөөг нь үнэлж, сайжруулах шаардлагатай асуудлыг олж тодорхойлно. Ийн хяналт тавьж, үнэлгээ хийснээр тамхины хайрцаг, сав, баглаа, боодол, шошгоны чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх бусад Оролцогч талын хүчин зүтгэлд нэмэр болохуйц нотлох баримт бүрдүүлэх боломжтой юм.

Тамхи үйлдвэрлэгчид хууль, журмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих ажлыг хууль, журам хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлмэгц нэн даруй санаачилж, цаашид тогтмол хийж хэвшүүлэх хэрэгтэй.

Хүн амд үзүүлэх нөлөө

Тамхин бүтээгдэхүүнийг салах, шошголох талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ зорилтот хүн амд нөлөөг үзүүлж байгаа эсэхийг тодорхойлох нь чухал. Эрүүл мэндийн анхааруулгын нүдэнд тусах байдал, ойлгомжтой байдал, мэдээллийн үнэн зөв байдал, мэдээллийн ач холбогдол, хувь хүнд хамаарах болон дурсагдах шинж, эрүүл мэндийн мэдлэг, эрсдэлийг ухамсарлуулах чадвар, зан үйлийг өөрчлөх сэдэл төрүүлэх чадвар, зан үйлийн бодит өөрчлөлт зэргийг Оролцогч талууд харгалзан үзэх хэрэгтэй.

Суурь болон хэрэгжилтийн дараах үзүүлэлт

Оролцогч талууд тамхин бүтээгдэхүүнийг савлах, шошголох талаар арга

хэмжээ хэрэгжүүлэхийн өмнө болон хэрэгжүүлсний дараа тодорхой хугацаанд энэхүү арга хэмжээний үр нөлөөг үнэлэн тодорхойлох хэрэгтэй.

Нөөц

Зорилт болон нөөц, хүний нөөцийн чадавхаас хамааран тамхин бүтээгдэхүүнийг савлах, шошголох талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний үр нөлөөг үнэлэх ажлын цар хүрээ, нарийвчлал Оролцогч талуудад харилцан адилгүй байна.

Түгээн дэлгэрүүлэх

Талууд хэрэгжилтийн хяналт, үнэлгээний үр дүнг хэвлэн нийтэлж, бусад Оролцогч тал болон олон нийтэд мэдээлнэ.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тамхины хяналт мэтийн чухал, байнгын хувьсан өөрчлөгдөж байдаг чиглэлээр дэвшил гаргахын тулд олон улсын хамтын ажиллагаа маш чухал. Конвенцийн хэд хэдэн зүйл заалтад конвенцийн хэрэгжилтэд ахиц гаргахын тулд Оролцогч талууд мэдлэг, туршлагаа солилцох, нэн ялангуяа конвенцид нэгдэн орсон хөгжиж буй орнууд болон шилжилтийн эдийн засаг бүхий улс орнуудын хэрэгцээг голлон анхаарах талаар заасан байна. Конвенцийн 22 дугаар зүйлд зааснаар техник, шинжлэх ухаан, эрх зүйн мэдлэгээ харилцан солилцох явдлыг дэмжихийн тулд Оролцогч талууд хамтран ажиллах нь конвенцийн 11 дүгээр зүйлийн хэрэгжилтийг дэлхий нийтэд бэхжүүлнэ. Ийм хамтын ажиллагааны нэг жишээ бол Оролцогч талууд эрүүл мэндийн зурагт анхааруулга хэрэглэх зөвшөөрлийг нэг нэгэндээ нэн даруй, хялбар, зардалгүй өгөх явдал юм. Олон улсын хамтын ажиллагаа нь дэлхий нийтийг тамхин бүтээгдэхүүний талаар үнэн зөв мэдээллээр хангахад тус болно.

Тамхин бүтээгдэхүүнийг савлах, шошголох арга хэмжээтэй холбоотой тамхины салбарын маргааныг шийдвэрлэх эрх зүйн болон бусад туршлага хуваалцах чиглэлээр Оролцогч талууд хүчин зүтгэл гаргах хэрэгтэй.

Конвенцийн 21 дүгээр зүйлд заасны дагуу тамхин бүтээгдэхүүнийг савлах, шошголох талаар олон улсын мэдлэгийг тэлэхийн тулд Оролцогч талууд бусад улсын туршлага, тайлантай танилцах нь зүйтэй.

-oOo-